



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 690

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийг нийтийн эзэмшилд
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.3, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндсэн хуулийн цэцийн нэр дээр амины орон сууцны зориулалтаар авсан 20000 кв талбай бүхий газар эзэмших эрхийг нийтийн эзэмшилд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Газар эзэмших эрхийг цуцлуулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.2.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ